



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 31 өдөр

Дугаар A/665

Арвайхээр

**Газар эзэмших эрх шинээр олгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” 12/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан Арвайхээр хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 5 дугаар баг, үйлдвэрчид-4 дүгээр гудамж, 417 тоотод байрлах 2га газрыг төслийн ялагч “Хотол констракшн” ХХК (6433731)-нд үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101414